

Манмин Мэдээ

№ 35 2013 оны 6-р сарын 2

Бүх алдар магтаал талархал нь дахин амилсан бидний Их Эзэнд байх болтугай



Христийн хамгийн чухал гурван том баярын нэг бол Эзэн дахин амилсан өдрийг тэмдэглэх баяр юм. Манмин Төв сүмд Эзний өдөр талархлын цуглаан, баярын тоглолт ба жүжиг, Ариун Зоогийн ёслол хийв. (Зураг 1) Итгэгчид гадаадаас ирсэн пасторууд болон итгэгчидтэй хамт дахин амилалтын найдварын тухай мөн мөнхийн амьдралын аз жаргалын талаар санал бодлоо хуваалцаж, Эзэнд бүх алдар магтаал талархалыг өргөлөө. (Зураг 2, 3)

Итгэгчдийн Эзэн рүү хандсан хайр гүнзгийрэх тусам энэ удаагын Эзэн дахин амилсаны баярыг илүү их аз жаргал баяр баясал, талархалтайгаар угтаж байна. 2013 оны 3-р сарын 31-ний Эзний өдрийн Үдээс хойшхи мөргөлөөр Ариун зоогны ёслол болов. Мөргөлд ойролцоогоор 10,000 гаруй салбар сүм, болон нэгдсэн сүм, хамтран ажиллагч сүмийн итгэгчид GCN (Жи Си Эн) телевизээр (www.gcnetv.org) оролцож, Эзний дахин амилсан баярыг илүү ач холбогдолтой, утга төгөлдөр тэмдэглэв.

Тэргүүн Пастор “Бидэнд өгсөн ерөөл” гэсэн сэдвээр сургаал номлов. Ариун зоогын өмнө Тэргүүн пастор угийн дуу хоолойн хүч чадлаар зуучлан залбирал хийж, сатан диавол болон бүх харанхуй хүчийг хөөн зайлуулав. Энэхүү залбиралаар пасторууд, сайн мэдээ тунхаглагчид, Леви бүлгийн ажилчид болон сүмийн бүх итгэгчид асар хурдацтай, хүчтэй ирсэн сүнслэг урсгалын хүчийг хүлээн авсан билээ.

Мөргөлд Хятад, Япон, Перу, Орос, Англи, Герман улсаас онцгой зочид ирж оролцлоо. Пастор Рапиел Германаас ирсэн Лонжи Яанга болон Мудида Кабангу нар сүмд хүрэлцэн ирж И Жей руг Тэргүүн пастораар дамжуулан хийж байгаа энэ эрх мэдэлт хүчийг гэрчилж Герман болон Европд энэ ариун сургаалыг тараахыг баглан хэлэв. Мөн тэд Тэргүүн пасторын энэхүү үйлчлэлийг одоо үеийн Христийн сүмүүдийн дотроос хамгийн сайн үлгэр жишээ үзүүлж байна хэмээн нэмж цохон тэмдэглэв.

Мөн Яанга пастор нь Тэргүүн пасторын 2004 онд Германд хийсэн Нэгдсэн их цуглаанд оролцож байжээ. Германчуудад Бурханы өгсөн ивээл болох тэр нэгдсэн их цуглааны талаар маш олон хүн ярьж байсан бөгөөд энэхүү цуглаанаар дамжуулан олон итгэгчдийн итгэл

өсөж, сүм чуулганууд хүчтэй сэргэж, хүчирхэг болсон гэж үргэлжлүүлэн хэлэв.

Кабангу пастор Дахин амилалтын өдрийн урлагын тоглолтыг үзээд сэтгэгдлээ хуваалцлаа. Тэрээр “Энэ тоглолт үнэхээр ер бусын гайхамшигтай байлаа. Хүн төрлөхтөний гэм нүглийг өөртөө үүрсэн бидний Эзэн Есүсийн зовлон шаналалыг үнэхээр бодитойгоор харуулж чадсан. Миний зүрх сэтгэл Есүсийн ташуурдуулж байгаа тэр үзэгдлийг хараад маш их өвдөж байлаа” гэв. Мөн тэд 2013оны 3-р сарын 3-нд тэд Тэргүүн пастораас ажил үйлчлэлийнхээ төлөө залбирал авсан юм.

Мөн түүнчлэн Англи улсаас ирсэн сайн мэдээ тунхаглагч Жейн Уполома Набанакула тэдний сүмийн итгэгчид мацаг барилт болон залбирлаар өөрчлөгдөхийг маш их хичээж байгаа бөгөөд Бурханы эрх мэдэлт хүчийг харж мэдэрсэн тухайгаа гэрчилсэн юм. Мөн тэрээр дахин амилалтын өдрийн ариун жүжгээр Есүсийн дагалдагч эмэгтэйчүүдийн

гашуудан уйлах мөн Есүсийн гадуур хувцасыг дөрвөн хэсэг болгон хувааж байгаа цэргүүдийг маш сайн нүдэнд харягдтал үзүүлж, хүмүүст хүргэж чадсан гэж хэлэв. Бидний Эзэн Есүс яаж зовж, шаналж цовдлогдсон тэр бодитоор харсан гэж нэмж хэллээ.

Маурине Ласфолк хүүхдүүдийнхээ хамт бүх зардалаа төлөн Манмин Төв Сүмийг зорин Шведээс хүрэлцэн иржээ. Мөн Английн Лондон Манмин Сүмийн гишүүн Юулия Горелова ч бас хамт ирсэн байна. Тэд сүнслэг ивээл ерөөлүүдийг дахин амилсан Эзний өдрөөр авч, бүх алдар магтаал талархалыг Бурханд өргөв. Мөн сайн мэдээ тунхаглагч Фар Ийст Радио нэвтрүүлгийн өмнөх продюсер байсан Вонг Пинг, Тэргүүн Пасторын цаг хугацааг даван гарсан залбирлаар сэтгэл санааны гутрал, стрессгүй байсан өвчнөөсөө эдгэрсэн сайн мэдээ тунхаглагч туслагч Вей Иран нар Манмин Төв Сүмд ирж дахин амилсан Эзний өдрөөр зочилсондоо туйлын байртай байгаагаа илэрхийлэв.

Израйльд Кристал Форумын зохион явуулсан хосууд болон залуучуудын цуглаан

Кристал Форум (Израйлийн пасторуудын холбоо)-ноос удирдан явуулсан хосууд болон залуучуудын цуглаан 2013 оны 3 сарын 17-19 хооронд Израйлийн Нахарияд боллоо. Энэ цуглаанд ойролцоогоор 300 хүн оролцсон бөгөөд оролцогчид Есүс Христийг алдаршуулж, Израйльд сайн мэдээ тараахын төлөө, ариун сүнслийн бялхам байдлаар хайран дотор хамтран ажиллахын төлөө залбирлаа.



Хайр бол атаархдаггүй, ихэрхдэггүй, бардам зан гаргадаггүй

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй” (1 Коринт 13:4).



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Бидний итгэлийн амьдралд маш муугаар нөлөөлдөг зүйл бол атаархал, атгаг хорон муу санаа юм. Ер нь бид ихэвчлэн танихгүй хүмүүст нэг их атаархаад, хорон муу санаа өвөрлөөд байдаггүй. Харин таньдаг хүмүүс, ойр дотныхоо найз нөхөддөө л атаархаж жөтөөрхөөд тэмцэлдээд байдаг. Жишээлбэл нэг ресторан ажиллуулдаг хүн ямар нэгэн компаний ажилтаныг хүлээн зөвшөөрөгдөж ажил нь дээшилж байгаа танилдаа атаархахгүй харин олон үйлчлүүлэгчтэй өөртэй нь яг адилхан хоолны газартай нэгэндээ атаархаж, дургүйцэж, тавгүйтдэг ордог байна.

Иймэрхүү атгаг санаа нь даамжирвал хорон үйлдэл хийхэд ч хүргэдэг.

Мөн бардамнах ч мөн адил юм. Өөрөөрөө бахархаж, хүлээн зөвшөөрөгдөх гэсэн сэтгэлд хэрүүл, маргаан үүсч тавгүй байдлыг бий болгодог.

Тэгвэл бид хэрхэн яаж атаархалгүй, бардамнадаггүй сүнслэг хайрыг олж авах вэ?

1. Хайр бол атаархдаггүй

Атгаг, хорон муу санаа нь бусдад атаархах, мөн цаашлаад эцэст нь хорон муу үйлдэл хийхэд хүргэдэг. Хэрэв та бусдын сайн сайхан байгааг, болон тэдний хайр халамж бүхий л сайн зүйлийг нь харахдаа нэг л сэтгэл тань эвгүйцээд байвал энэ нь таньд атаархал, атгаг санаа байна л гэсэн үг.

Хэрэв таны зүрх сэтгэлд атгаг санаа, атаархал жөтөөрхөл байвал хэн нэг танаас илүү авьяас чадвартай, илүү баян чинээлэг хүнийг харахдаа та сэтгэл тань нэг л эвгүйрхэж, таньд баяр бахдалгүй болдог байна. Тантай хамт ажилдаг хүн тань маш хурдан амжилтанд хүрч харин та нөгөө л өөрийнхөө байр суурин дээрээ байгаад байвал танд гуниглах, эвгүйцэх сэтгэл төрж улмаар ажил хийх ч хүч чадалгүй болдог. Энэ атгаг санаа, нь хүний урмыг хугалж, уйтгар гунигт автуулдаг юм. Хэрэв та хэн нэгэнтэй өөрийгөө харьцуулвал бүр их уур чинь хүрч, улам л муу муухай мэдрэмж

таньд төрж, өөрийгөө зовоох болно.

Харин таньд сүнслэг хайр байгаа бол та үнэн зүйлийг хараад аз жаргалтай, баяртай байж чаддаг байна. Сүнслэг хайр байгаа учраас бусад хүмүүст ямар нэгэн сайхан зүйл тохиолдвол та ч бас баярлаж, аз жаргалтай болдог. Харин таны сэтгэл гонсойж, урам хугарч хүчгүй болж байвал танд тэр хэмжээний хайр байхгүйг харуулж байгаа юм. Энэ нь таны дотор одоо хүртэл “Би” гэсэн өөрийгөө өргөмжлөх зан чанар байгааг илэрхийлж байна. Хэрэв таны доторх “Би” хайрыг хүлээн авахыг хүсэхэд, таны бардам байдал хаггагдаж, хорон муу атгаг санаа сэтгэл зүрхэн дотор чинь буцлах болно.

Иймэрхүү атаархал бүр даамжирвал бусдад хохирол учруулах үйлдэл ба, янз бүрийн хэл ам, хэрүүл хийхэд хүргэдэг. Энэ бол нөгөө таны дотор байсан агаа хорсол одоо яг биелэлээ олж, бодитоор хэрэгжүүлж байгаа нь тэр. Энэ нь Галат 5:19-21д бичигдсэнчлэн махан биений үйлсийн баталгаа болж байна. Тиймээс атаархал бол аврал авахад үнэхээр хэцүү маш том саад болдог.

Жишээ нь Израйлийн анхны хаан Саул Давидд атаархаж, хорсож байснаас болж маш хэцүү хөөрхийлэлтэйгээр нас барсан. Давид бол Филистчүүдийн баатар аварга биетэн Голиатын гараас улс орноо аварсан баатар байсан. Голиат бол Филистын хамгийн шилдэг, гарамгай дайчин, байсан бөгөөд маш өндөр бас хүрэл хуяг дуулгатай бүрэн зэвсэглэсэн байлаа. Тэр 40 өдрийн турш Бурханыг болоод Израйлийн бүхэл бүтэн цэргийн хороог гутаан доромжилж, хорон муу үгээр дарамталж байлаа. Тэр үед Саул хаан болоод Израйлийн цэргүүд тэр чигээрээ түүнээс айн чичирч байв. Гэтэл тийм байдлаас Давид гэнэт гарч ирж өчүүхэн жижигхэн дүүгүүр чулуугаар л тэгж их доромжилж байсан Голиатыг алсан билээ. Тэгээд эцэст нь Израйль ялж, Давид Израйлийн ард түмний баатар болж олны хүндэтгэл хайрыг авч чадсан билээ.

Үүнээс хойш Саул хаан Давидаар цэргээ удирдуулахаар болсон ч түүний сэтгэл атаархал, хорон муу бодолд хөтлөгдөж байв. Филистчүүдыг ялан дийлсэн энэ үйл явдлаас хойш Давидын нэр ард түмэн дунд алдаршиж үй олон хүн түүнийг магтан сайшааж байв. 1 Самуел 18:7д Эмэгтэйчүүд гарч ирэн “Саул мянгыг алж, Давид түмийг алав” хэмээн дуудалдав гэж дурдсан байдаг. Үүнийг нь сонссон Саул хаан бүр их уурлан хилэгнэж байсан.

Тэр “Тэд Давидад түмийг хамааруулж, надад мянгыг өгөв. Одоо түүнд хаанчлал л дутуу байна уу?” хэмээн хэлжээ. Тэр өдрөөс хойш Саул Давидыг сэжиглэн харах болов (1 Самуел 18:8-9). Энэ явдлаас хойш тэр Давидыг алахыг хичээж байлаа. Саул агаа хорсолын муу сүнсэнд баригдаж

зовж шаналж Давид руу жад шидсэн ч Давид түүнд зориулан босоо ятга тоглож өгч байв. Тэр өөрийн хамгийн сайн цэрэг дайчдаа Давидыг алах тушаал өгч, мөн филистчүүдээр алуулахаар хуйвалдаан зохиож байсан. Тэр филистчүүдтэй хийсэн тулалдаанд үхэх өдрөө хүртэл Давидд атаархсан хэвээрээ байлаа.

Иов 4:8д “Миний харсны дагуу гэм бурууг хагалж, зовлон зүдүүрийг таригчид түүнийгээ хурааж авдаг”, Сургаалт үгс 14:30д “Амар тайван зүрх бие махбодод амийг өгдөг бол хүсэл тачаал ясан дах идээ бээр юм” гэж бичсэн байдаг. Хэрэв та хорон мууг үйлдвэл энэ яг бумэринг шиг тань руу эргэж ирдэг. Гэр орон, ажил төрөлд тань өвчин зовлон, гай гамшиг тохиолдвол таны л тарьсан үр соёолж байгаа нь тэр гэдгийг ухаарах. Атаархал, хорон муу санаа нь бидэнд зөвхөн хор хохирол л учруулж, сүнслэг ивээл авахад асар том саад бэрхшээл, хаалт болж байдаг учраас бид бүхэн түүнийг бүр мөсөн хаях хэрэгтэй.

2. Хайр бол ихэрхдэггүй

Ихэрхэх, онгирох гэдэг нь хэн нэгэнд магтуулах, өөрийгөө дөвийлгөн онгирч сагсуурах гэсэн утгатай. Ихэнх хүмүүс ямар нэг зүйлээрээ бусдаас жаахан дээр байвал бардаж, онгирч сагсууран ихэрхдэг байна. Энэ нь бусдаас магтаал авч, олонд танигдах хүсэлтэй байгаа учраас тэр юм. Гэтэл тэд өөрсдөө бусдын сайн хийсэн зүйлсийг хүлээн зөвшөөрч, магтаж урамшуулахдаа хойрго ханддаг. Тэд бусад хүмүүс олонд танигдаж, амжилтанд хүрэх тусам тэдний өөрсдийнх нь амжилт дарагдаж, ил гарч чадахгүй гэж боддог учраас дандаа л шүүмжилж байдаг байна. Ихэрхэх нь заримдаа хэрүүл тэмцэлд хүртэл хүргэдэг. Та өөрийгөө их өндөрт гарч нэр хүндтэй боллоо гэж боддог байж магадгүй. Гэвч үр дүн нь харин яг эсрэгээрээ байдаг.

1 Иохан 2:15-16 д “Ертөнц болон ертөнцөд байгаа зүйлсийг бүү хайрла, хэрэв хэн нэгэн нь ертөнцийг хайрладаг бол түүний дотор Эцэгийн хайр байхгүй. Учир нь ертөнцөд байгаа бүхэн тухайлбал, махан биений хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардам бахдал нь Эцэгээс бус харин энэ ертөнцөөс ирдэг юм” гэсэн байдаг.

Энд “Амьдралын бардам бахдал” гэдэг нь энэ дэлхийн зугаа цэнгэл баяр баясалаар сайрхах, бардамнаж, өөрийгөө өндөрт өргөх хүний хүслийг хэлж байна. Махан биений хүн нь гэр бүлийнхээ нэр хүндээр, нэр төрөөрөө, эрх мэдлээрээ, үнэтэй машин эд зүйлсээрээ, байшин, үнэт эдлэлээрээ гайхуулж бардамнадаг байна. Энэ дэлхийн амьдралд ашиг тустай, ач холбогдолтой гэж үздэг учраас тэд өөрсдийнхөө ойр дотны ах дүү, хамаатан садныхаа нэр хүнд, эрх мэдэлтэй хүмүүсээр ч

гайхуулан сайрхдаг байна.

Гэвч ингэж онгирч, сагсуурч, гайхуулж, бардамнах нь чухам яг юунд хэрэгтэй вэ? Номлогчийн үгс 1:2-3д “Наран доор ажиллагч хүмүүний бүх хөдөлмөрийн үр ашиг нь юу вэ?” гэсэн байдаг. Мөн Дуулал 103:15д бичсэн шиг хүний амьдрал хээрийн цэцэг шиг дэлгэрдэг ч эцэстээ хагдан, хаган унадаг. Энэ дэлхийн бахдал, бардамналаар бид жинхэнэ амьдралын үнэ цэнийг олж авч чадахгүй. Харин ч би бид Бурханы эсрэг дайсан болж, үхлийн зам руу явах юм.

3. Эзэн дотор сайрх.

Худал хуурмаг байдлыг авч хаясаны дараа бидэнд жинхэнэ хайр ирдэг. Энэ нь бидэнд өөрөөрөө юм уу энэ дэлхийн зүйлсээр бардамнах, сайрхах гайхуулах хүсэлгүй болдог учраас юм. 1 Коринт 1:31-г уншвал “Сайрхагч нь Эзэн дотор сайрхаг” гэсэн байдаг. Энэ нь бид өөрсдийнхөө нэр алдрын төлөө биш харин Бурхан Эзэний алдрын төлөө сайрхаж бай гэж хэлж байгаа юм.

Энэ бол бидний Аврагч Их Эзэний загалмайн хайраар бахархаж, Бурханы өгсөн ивээл ба хариултаар мөн гэрчлэлээр Бурхандаа алдрыг өргөн сайрхдаг. Энэ мэт Эзэн дотор сайрхвал Бурхан баярлан таалж, бидэнд сүнс болон махан биений ивээл, ерөөлийг хоёуланг нь өгөх болно.

Гэвч зарим итгэгчид Бурханд алдрыг өргөн ярьж байхдаа өөрсдөөрөө бардамнах тохиолдол байдаг. “Би ингэж хичээсэн учраас, ийм ерөөлийг авсан” өөрсдийгөө үнэлэн дүгнэдэг байна. Эцэстээ сатанд уруу татагдаж, сорилтонд унах үе ч бий.

Энэ дэлхийн бардамнах зүйл нь бидэнд мөнхийн амийг болоод сэтгэл хангалуун байдлыг өгч чадахгүй билээ. Харин ч бүр эсрэгээр биднийг ямар ч ашиггүй шуналыг бидний дотор тарьж, үгүйрэл хоосрол, сүйрэл рүү хөтөлдөг. Тиймд бид өөрсдийнхөө зүрх сэтгэлийг Тэнгэрийн орны хүсэл мөрөөдлөөр дүүргэвэл энэ дэлхийн сайрхал, бардамналыг хаях хүч дээрээс өгөгддөг. Бид зүрх сэтгэлээ зөвхөн үнэнээр дүүргэсний дараа махан биений сайрхал, бардамнал болоод дэлхийн зүйлс юу ч үгүй болох болно. Өсөж томроод нас бие гүйцсэний дараа хүүхэд насандаа тоглож байсан тоглоом, мөн янз бүрийн жижиг сажиг зүйлс ч хэрэггүй болдогтой адилхан юм.

Хайрт итгэгч ах дүү нар минь, Элч Паул Галат 6:14д “Харин бидний Эзэн Есүс Христийн загалмайгаар сайрхахаас өөр нь надад бүү байг” гэж хэлсэн шиг та бүхэн зөвхөн биднийг аварч бидэнд Тэнгэрийн орныг өгсөн Есүс Христээр сайрхаж, Түүний нэрийг өндөрт өргөж явахыг бидний Их Эзэн Есүс Христийн нэр дээр хүсэн ерөөл!

Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
 www.manmintv.org

Бидэнд байдаг хорон муугын хамгийн том дөрвөн үндэс

Сургаалт үгс 17:3д “Галын дөлөөр мөнгө ба алтыг цэвэршүүлдэг бол Эзэн хүмүүний зүрхийг шалгадаг” гэжээ. Өөрөөр хэлбэл Бурханы алдагдсан дүр төрхийг буцааж олж, Тэнгэрийн Орон Шинэ Иерусалимд хамгийн үзэсгэлэнтэй сайхан газар орохын тулд өөрийгөө хоосолж, зүрх сэтгэлдээ байгаа хорон муугийн бүх хэлбэрүүдийг хаях хэрэгтэй. Гэвч үүнийгээ мэдэж, бидний дотор маш гүн суулгагдсан хорон муугийн үндэснүүдийг хаях нь тийм ч амар хялбар зүйл биш учраас Бурхан бидэнд сорилтуудыг зөвшөөрдөг юм. Тэгээд бид ямар хамгийн том хорон муугийн үндэснүүдийг таслаж хаях хэрэгтэй вэ?

Амархан өөрчлөгддөг махан биеийн шинж чанар болох “Худал хуурмаг”

1

Хуурамч зан чанартай хүн голдуу худлаа ярьдаг. Тийм хүн хүнд амласнаа биелүүлдэггүй бөгөөд өөртөө амласан зүйлээ ч бас сахиж биелүүлдэггүй байна. Үг яриа дамжуулах үед ч хэтрүүлэх эсвэл дутуу хэлдэг.

Зарим хүн зориуд хүнийг мэхлэхээр худлаа ярьдаг ч зарим нь хүмүүс ч хэвшил мэт сурсан зангаараа худлаа ярьж, мөн хэн нэгний нөлөөнд орж худлаа ярих тохиолдол ч байдаг. Тэр ч бүү хэл өөрийгөө худлаа ярьж байгаагаа ч мэдэхгүй ба хэлж буй үг нь худал болохыг ч мэддэггүй үе ч бий.

Матай 26:34-35д Есүс “Үнэнээр Би чамд хэлье. Энэ шөнө азарган тахиа донгодохоос

өмнө чи Намайг гурван удаа үгүйсгэнэ дээ” гэв. Тэгтэл Петр Түүнд “би хичнээн Тантай хамт үхэх болсон ч Таныг үгүйсгэхгүй” гэж хэлэв. Гэвч тэр шөнө Петр азарган тахиа гурван удаа донгодохоос өмнө Есүсийг үгүйсгэв.

Мэдээж Петр тэр үгийг чин сэтгэлээсээ хэлсэн. Гэвч тэр Түүнтэй хамт байхдаа хэлж байсан амандаа хүрээгүй. Хуурамч, хувирамтгай зантай хүмүүс өөртөө амласан амлалтандаа ч хүрч чаддаггүй, гэмшиж ч чаддаггүй байна. Тиймээс, угийн худалч, хувирамтгай зангаа олж мэдээд үнэнч шударга, шулуун зантай хүн болохын тулд бүрмөсөн хаях хэрэгтэй.

Бурханы хүслийг дагахгүйгээр өөрийн эрх ашгийг хайх хүсэл буюу “Шударга бус сэтгэл”

2

Шударга бус сэтгэл гэдэг нь “зөв шударга үйлддэггүй” гэсэн үг тул зүрх сэтгэл, бодол санаа, болон үйлдэл буруу гэсэн үг юм. Хэрэв бүх хүмүүс хууль дүрэм, тушаалыг төгс сахиж мөрддөг бол нийгэмд ямар ч асуудалгүй байх байсан. Яг үүнтэй адил Бурханы хүүхдүүд Тэнгэрийн орны иргэнийхээ хувьд библийн 66 номд бичигдсэн Бурханы үгийн дагуу амьдрах ёстой юм.

Аливаа зүйлийг үнэн, зөв шударгаар биш худал хуурмаг буруу замаар хийдэг бөгөөд хувийн эрх ашгийг бодож, олз ашиг хайж, бүхнийг худал хуурмаг дотор хийдэг байна. Хитийн хүү Абрахамд Сараг оршуулах талбайг зүгээр өгөхийг хүссэн ч тэр түүнд оршуулгын газрын мөнгийг бүрэн гүйцэд төлж байсныг харж болох юм (Эхлэл 23:13).

Даниел болон түүний гурван найз ч бас энэ дэлхийн зүйлтэй хугалдалгүй зөвхөн итгэлээрээ л зөв шударга байдлыг дагасан. Ийн үйлдэхэд Даниел арслангийн торон дотор хаягдаж, гурван найз нь хамт зууханд шидэгдэж байсан. Гэсэн ч тэд ердөө ч бэртэж гэмтээгүй, бүр үс ч хуйхлагаагүйгээр Бурханыг алдаршуулсан билээ (Даниел 6:16-23, 3:19-27).

Энэ мэт өөрийн эрх ашгийг өчүүхэн төдий ч хайлгүй өөрийн амийг ч хайрлахгүй байх ийм сэтгэлээс үүн шиг зөвт үйлс гарч шударга байдлыг сахиж чадах юм. Элч Паул ямар ч хүнд хэцүү үед зөвхөн үнэний замаар явж, амьдарч байсан учраас тэр 1Коринт 11:1д “Би Христийг дуурайдаг шиг намайг дуурайцгаа” гэж хэлж чадсан юм.

Зүрх сэтгэл болон хэлсэн үгээ захирч чаддагүй “Зальт сэтгэл”

3

Хэрэв та ямар нэг юм хийхээр төлөвлөөд тэрийгээ хийж чадахгүй, төлөвлөгөөгөө өөрчилдөг эсвэл ашиг хонжоо хайдаг бол таны зүрх сэтгэлд зальт сэтгэл байна гэсэн үг. Хичнээн бага зүйл байсан ч хэрэв та бодлоо өөрчилж л байвал таны дотор хэдийн зальхай, хувирамтгай зүрх сэтгэл байгаа гэсэн үг юм.

Таны зүрх сэтгэлээ барьж чадахгүй байдлыг зальжин гэдэг ба ийм хүмүүс анх төлөвлөсөн зүйлээ амархан өөрчлөх юм уу эхлээд итгэмжтэйгээр хамтдаа ажиллах юм шиг санагдсан ч сүүлдээ бүр урвадаг.

Хэрэв танд ийм сэтгэл байвал энэ дэлхийн нэр

алдар, эрх мэдэл, эд хөрөнгө гэх мэтийн сорилтонд унахад маш амархан байх болно. Тийм учраас бид бүхэн өөрсдийн сэтгэл зүрхнээсээ зальжин занг авч хаяж, оронд нь сэтгэл зүрхэндээ үнэнч шударга байдал руу ойртох тусам Бурханы хаанчлалын төлөө илүү гайхамшигтайгаар ашиглагдах болно.

Тиймээс бид сэтгэл зүрхэндээ төлөвлөснөө зайлшгүй хийж, хэлсэн үгэндээ эзэн болж байх ёстой. Хэрэв та үүнийг л хийж чадахгүй юм бол Бурхантай итгэлцлийн холбоо тогтоож чадахгүй. Бид өөртөө болон бусдад амласан амлалтандаа хүрч үйлдэх тусам зальжин муу зан чанар хаягдаж үнэнч сэтгэл бидний зүрхэнд суух болно.

Үзэн ядах нь өөрөөсөө илүү бусдын хүндэтгэлийг ч хүлээж чадахгүй.

4

Хэрэв та хэн нэгнийг болон ямар нэг зүйлийг үзэн ядаж байвал та бусдыг хүндэтгэдэггүй, тэднийг дорд үзэж байна гэсэн үг. Энэ байдал танд байгаа бол та эрх мэдлээрээ бусдыг дорд үзэж, басамжилж мөн үл тоодог гэсэн үг юм. Бусдыг өөрөөсөө дорд үзэн басамжилж байгаа бүх үйлдэл чинь өөрийгөө өргөмжлөх, ихэмсэг бардам зангаас л болж байгаа юм.

Жаахан, жижиг зүйл гэлтгүй ямар нэг зүйлийг хийхдээ зөвхөн Эзэнд хийж өгч байна гэсэн сэтгэлээр хийх нь их чухал. Ахан дүүсээ хайрлаж байгаа хайр бол Эзэнийг хайрлаж байна гэсэн үг учраас хэрэв та бусдыг үзэн ядаж байвал Бурханыг бас үзэн ядаж байгаатай адилхан юм.


Израйльчууд Бурхан тэднийг захирах Хаан нь байхаас татгалзаж Самуелаас өөр хаан томилж өгөхийг хүссэн тухай 1 Самуел 8:5-7 д бичигдсэн байдаг. Мөн Израйлийн хүүхдүүд Мосегийн эсрэг биш харин Бурханы эсрэг гомдол мэдүүлж байгаа тухай Египетээс гарсан нь 16:8д байдаг.

Бид хичнээн олон хүн байсан ч Эзэн дотор нэг бие мэт байх ёстой тухай 1Коринт 12:20д бичигдсэн байдаг. Итгэгчид бид хүн нэг бүр Христийн бие юм. Хэрэв нэг биеийн эрхтэнүүд болсон итгэгчид бид

бие биенийгээ үзэн ядаад байвал бүтэн бие нь үргэлж зовж шаналж, амар тайван байж чадахгүй, сайн ажиллаж ч чадахгүй шүү дээ.

Биеийн бүх эрхтэнүүд өөр өөрийн үүрэгтэй, тэр дунд үүрэггүй, хэрэггүй эрхтэн гэж нэг ч байдаггүй билээ. Энэ нь ядуу, сул дорой, боловсрол мэдлэггүй, сайн бэлтгэгдээгүй, замбараагүй хүн бидний дунд байсан ч бид бие биенийгээ муулж, үзэн ядах сэтгэл байх ёсгүй гэдгийг хэлж байна. Жишээ нь ам нүдэнд “та нар бол биенд нэг их чухал биш эрхтэн” гэж хэлж байгаатай адил юм. Хэрэв нүд байхгүй бол ам ганцаараа бүхэл бүтэн биеийг удирдаж чадахгүй төөрүүлж, нүх рүү унагаана шүү дээ. Ийм байвал ямар ч утгагүй хэрэг болох юм.

Филиппой 2:32-ийг уншвал “Юуг ч өрсөлдөх сэтгэлээр бүү хий эсвэл бардам зангаар бүү хий. Харин даруугаар бие биеэ өөрөөсөө дээр гэж үз” гэсэн байдаг. Тиймээс та бусдыг өөрөөсөө илүү дээр гэж үзэж, тэдэнд үйлчилж, хэзээ ч дорд үзэхгүй байх нь маш чухал юм. Та хэзээ ч өөрийнхөө хариуцсан үүрэг албаа болон байр сууриа маргаж болохгүй. Бүр та олны танил болж хүндэтгэл хайрыг нь хүлээсэн ч даруу байж, хувируулахаар зүтгэх хэрэгтэй.



1-р үзэгдэл
Есүсийн үйлчлэл

Бүх хүн төрөлхтөний аврагчаар ирсэн Бурханы Хүү Есүс нь гурван жилийн үйлчлэлийнхээ турш тэнгэрийн орны сайн мэдээг тунхаглаж, төрөл бүрийн өвчтэй болон сул дорой хүмүүсийг эдгээж байлаа.

2013 он Эзэн дахин амилалтын баярын жүжиг “Эзэн бол Христ”



Үзэгдэл 3

Эзэний дахин амилалт болон дээшээ хөөрөн явсан нь

Эзэн үхлийн хүчийг ялан дийлж, оршуулагдсаныхаа дараа гурав дахь өдрөө дахин амилсан юм. Тэрээр 40 хоногийн турш Өөрийгөө амьд гэдгээ баглан харуулаад Галилын олон эрчүүдийг харж байхад Тэнгэрийн Орон руу хөөрөн явж дахин амилалтын итгэл найдварыг өгсөн билээ.

2-р үзэгдэл
Есүсийн зовлон

Бидний гэм нүглийн өрийг төлөхийн тул шударга ёсны хуулийн дагуу Есүс өргөст титэм зүүж, ташуурдуулж, хөл, гараа хадаасаар модон загалмайд хадуулсан нь.



2013 оны 3сарын 31ний тав дах өдрийн оройн цуглааны 2дах хэсгээр Эзэн дахин амилсан тухай ариун жүжиг тоглон үзүүлээ. Жүжгээр библи дээр бичигдсэнчлэн Есүсийн үйлчлэл, зовлон шаналал, загалмайд цовдлогдсон, дахин амилалт болон дээшээ тэнгэр өөд хөөрөн явсан тухай эргэн санан дурслаа.

Үзэгчдэд Эзэний хайр болон дахин амилалтын итгэлийг найдварыг нэмж, гүн суулгаж байв. Жүжгийн өгүүлэгээр Магдалын Мариа болон элч Петр, Иохан, нар Эзэнтэй хамт амьдарч байсан үеэ дурсан санаж байгаа тухай гардаг. Дэд хууль 31:19, 22 дээр бичсэнчлэн Бурхан Өөрөө Израйлийн хөвгүүдэд зориулж бичсэн

дууг Нисси оркестра дуулж, жүжигчид, найрал дуучид онцгой дуу дуулж алдрыг өргөв. Тэдний энэхүү тоглолт нь үзэгчдийн сэтгэлийг үнэхээр их хөдөлгөж байлаа. Мөн түүнчлэн 5 хэмийн налууутай тусгайлан засагдсан тайзнаас үзэгчдийн суудалд хичнээн хол суусан ч сайн харах боломжтой байсан юм.

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здон, Гуро-гу, Сеул, 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин